



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор сумын 5 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/7/НА-СТА-ТШЗ

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Ж.Өсөхбаяр Утас: 99890393 Цахим хаяг: usukhbayarj@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	---

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	11
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт	13
4.1 Албан шаардлага	13
4.3 Зөвлөмж	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.Аудитын санал дүгнэлт



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 64101
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.06.24 № 2/100

танай _____ -ны № _____ -т

Г АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ Г

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын 5 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор сумын 5 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

• 005020477

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Б.МӨНХБАТ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	46,894,997.56	84,887,776.36
35	БАРАА МАТЕРИАЛ	46,894,997.56	84,887,776.36
351	Түүхий эд материал	20,426,639.16	29,803,980.16
35110	Тусгай зориулалттай материал	17,284,639.16	21,158,730.16
35130	Эм боох материал	3,142,000.00	8,645,250.00
354	Хангамжийн материал	26,468,358.40	55,083,796.20
35410	Бичиг хэргийн материал	477,750.00	00.00
35420	Аж ахуйн материал	7,841,700.40	7,641,436.20
35470	Бусад хангамжийн материал	18,148,908.00	47,442,360.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,272,209,225.87	1,227,681,687.87
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,272,209,225.87	1,227,681,687.87
392	Биет хөрөнгө	1,122,759,225.87	1,078,231,687.87
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,189,567,657.00	1,189,567,657.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-124,335,270.21	-178,024,358.61
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	80,520,727.00	91,822,307.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-46,891,825.10	-49,336,255.11
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	33,502,996.28	38,128,696.28
39208	Хуримтлагдсан элэгдэл	-17,514,305.11	-15,063,025.26
39214	Бусад үндсэн хөрөнгө	20,092,024.15	7,426,864.15
39215	Хуримтлагдсан элэгдэл	-12,182,778.14	-6,290,197.58
393	Биет бус хөрөнгө	149,450,000.00	149,450,000.00
39301	Програм хангамж	919,720.00	919,720.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-919,720.00	-919,720.00
39303	Бусад биет бус хөрөнгө	149,450,000.00	149,450,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,319,104,223.43	1,312,569,464.23
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	20,538.00	85,153.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	20,538.00	85,153.00
413	Өглөг	20,538.00	85,153.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	20,538.00	85,153.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,319,083,685.43	1,312,484,311.23
51	Засгийн газрын хувь оролцоо	1,319,083,685.43	1,312,484,311.23
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	457,736,119.00	457,736,119.00
51101	Өмч: - төрийн	457,736,119.00	457,736,119.00
512	Хуримтлагдсан үр дүн	345,043,712.60	338,444,338.40
51210	Өмнөх үеийн үр дүн	345,043,712.60	345,043,712.60
51220	Тайланг үеийн үр дүн	00.00	-6,599,374.20
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	516,303,853.83	516,303,853.83
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,319,104,223.43	1,312,569,464.23

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,149,930,174.00	604,410,619.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	546,654,974.00	34,757,022.00
120	Нийтлэг татварын бус орлого	546,654,974.00	34,757,022.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	546,654,974.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	397,968.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	546,257,006.00	00.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	00.00	2,275,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	00.00	32,482,022.00

Баянхонгор сумын 5 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	603,275,200.00	569,653,597.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	501,321,100.00	467,229,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	501,321,100.00	467,229,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,923,800.00	12,293,540.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,923,800.00	12,293,540.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	97,030,300.00	90,130,557.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	97,030,300.00	90,130,557.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	628,231,541.95	605,061,378.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	628,231,541.95	605,061,378.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	617,403,362.95	590,076,168.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	351,719,932.53	343,139,723.00
210101	Үндсэн цалин	272,398,345.53	255,863,623.00
210102	Нэмэгдэл	55,917,596.00	59,242,000.00
210104	Урамшуулал	23,403,991.00	28,034,100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,782,989.47	44,416,592.00
210201	Тэтгэврийн даатгал	29,020,348.00	27,996,823.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,765,840.13	6,353,742.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,234,702.00	2,959,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,086,574.19	739,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,675,525.15	6,366,827.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	95,656,655.00	89,630,557.00
210301	Гэрэл, цахилгаан	7,311,169.00	3,455,309.00
210302	Түлш, халаалт	75,152,100.00	74,466,992.00
210303	Цэвэр, бохир ус	13,193,386.00	11,708,256.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,406,107.60	12,161,143.20
210401	Бичиг хэрэг	220,300.00	240,500.00
210402	Тээвэр, шатахуун	1,400,000.00	1,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,450,400.00	1,439,395.00
210404	Ном, хэвлэл	67,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	910,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,846,500.00	3,981,305.00
210408	Бараа материал акталсны зардал	20,511,907.60	5,259,943.20
2105	Нормативт зардал	41,453,500.00	19,948,030.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,750,400.00	4,492,700.00
210502	Хоол, хүнс	39,508,100.00	14,947,330.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	195,000.00	508,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,064,084.00	3,985,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	142,600.00
210604	Урсгал засвар	3,064,084.00	3,843,200.00
2107	Томилолт, зочны зардал	64,000.00	110,000.00
210702	Дотоод албан томилолт	64,000.00	110,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	700,500.00	1,207,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	400,500.00	682,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	350,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	175,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	55,555,594.35	75,476,923.65
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	2,659,650.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн даллага хийх	3,853,716.00	2,821,250.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	51,701,878.35	69,996,023.65
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,828,179.00	14,985,210.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,119,600.00	12,969,740.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	147,000.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,923,800.00	12,293,540.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	48,800.00	676,200.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	673,645.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	673,645.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,034,934.00	2,015,470.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,034,934.00	2,015,470.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	521,698,632.05	-650,759.85
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	5,948,614.35
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	5,948,614.35
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-5,948,614.35
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	521,698,632.05	-6,599,374.20

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /Төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	603,275,200.00	569,653,597.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	603,275,200.00	569,653,597.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	501,321,100.00	467,229,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	501,321,100.00	467,229,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,923,800.00	12,293,540.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,923,800.00	12,293,540.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	97,030,300.00	90,130,557.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	97,030,300.00	90,130,557.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	558,560,750.00	540,511,497.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	558,560,750.00	540,511,497.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	547,732,571.00	525,526,287.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	349,816,116.00	342,553,700.00
210101	Үндсэн цалин	272,377,807.00	255,277,600.00
210102	Нэмэгдэл	54,034,318.00	59,242,000.00
210104	Урамшуулал	23,403,991.00	28,034,100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,268,300.00	44,938,000.00
210201	Тэтгэврийн даатгал	30,102,400.00	30,297,096.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,541,400.00	3,543,504.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,833,200.00	2,959,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	708,300.00	739,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,083,000.00	7,398,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	95,356,655.00	89,630,557.00
210301	Гэрэл, цахилгаан	7,311,169.00	3,455,309.00
210302	Түлш, халаалт	74,852,100.00	74,466,992.00
210303	Цэвэр, бохир ус	13,193,386.00	11,708,256.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,429,800.00	9,137,400.00
210401	Бичиг хэрэг	176,200.00	251,900.00
210402	Тээвэр, шатахуун	1,400,000.00	1,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэгийн төлбөр	1,450,400.00	1,464,395.00
210404	Ном, хэвлэл	97,900.00	1,828,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,000,000.00	500,000.00
210406	Бага үнэгэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,305,300.00	4,093,005.00
2105	Нормативт зардал	40,391,950.00	20,629,530.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,591,400.00	4,012,200.00
210502	Хоол, хүнс	35,102,850.00	15,827,330.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	697,700.00	790,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,300,200.00	6,248,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,000,000.00	2,477,900.00
210604	Урсгал засвар	2,300,200.00	3,770,200.00
2107	Томилолт, зочны зардал	64,000.00	110,000.00
210702	Дотоод албан томилолт	64,000.00	110,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,043,800.00	1,349,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	743,800.00	759,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	350,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	240,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,061,750.00	10,929,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	106,000.00	8,320,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,955,750.00	2,609,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,828,179.00	14,985,210.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,119,600.00	12,969,740.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,923,800.00	12,293,540.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	195,800.00	676,200.00

Баянхонгор сумын 5 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		
		673,645.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	673,645.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг		
		5,034,934.00	2,015,470.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,034,934.00	2,015,470.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	44,714,450.00	29,142,100.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	44,714,450.00	29,142,100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	44,714,450.00	29,142,100.00
2200	Дотоод эх үүсвэрээр		
		44,714,450.00	29,142,100.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	44,714,450.00	29,142,100.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-44,714,450.00	-29,142,100.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр /	
					Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	308,286,119.00	00.00	62,070,425.59	370,356,544.59	
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	308,286,119.00	00.00	62,070,425.59	370,356,544.59	
C07	Тайлант үеийн үр дүн	149,450,000.00	00.00	-140,742,731.42	8,707,268.58	
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	457,736,119.00	516,303,853.83	345,043,712.60	1,319,083,685.43	
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	457,736,119.00	516,303,853.83	345,043,712.60	1,319,083,685.43	
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	457,736,119.00	516,303,853.83	345,043,712.60	1,319,083,685.43	
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-6,599,374.20	-6,599,374.20	
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	457,736,119.00	516,303,853.83	338,444,338.40	1,312,484,311.23	

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		/ төгрөгөөр /	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	562,316,300.00	555,344,587.00	6,971,713.00	98.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	562,316,300.00	555,344,587.00	6,971,713.00	98.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	561,640,100.00	554,668,387.00	6,971,713.00	98.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	342,553,700.00	342,553,700.00	00.00	100.0
210101	Үндсэн цалин	255,277,600.00	255,277,600.00	00.00	100.0
210102	Нэмэгдэл	59,242,000.00	59,242,000.00	00.00	100.0
210104	Урамшуулал	28,034,100.00	28,034,100.00	00.00	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,938,000.00	44,938,000.00	00.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	30,141,500.00	30,297,096.00	-155,596.00	100.5
210202	Тэтгэмжийн даатгал	3,699,100.00	3,543,504.00	155,596.00	95.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,959,300.00	2,959,300.00	00.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	739,900.00	739,900.00	00.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	7,398,200.00	7,398,200.00	00.00	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	94,586,800.00	89,630,557.00	4,956,243.00	94.8
210301	Гэрэл, цахилгаан	4,198,600.00	3,455,309.00	743,291.00	82.3
210302	Түлш, халаалт	74,306,200.00	74,466,992.00	-160,792.00	100.2
210303	Цэвэр, бохир ус	16,082,000.00	11,708,256.00	4,373,744.00	72.8
2104	Хангамж, бараа материалын зардал	9,137,400.00	9,137,400.00	00.00	100.0
210401	Бичиг хэрэг	258,600.00	251,900.00	6,700.00	97.4
210402	Тээвэр, шатахуун	1,000,000.00	1,000,000.00	00.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэгийн төлбөр	1,436,000.00	1,464,395.00	-28,395.00	102.0
210404	Ном, хэвлэл	1,828,100.00	1,828,100.00	00.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500,000.00	500,000.00	00.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,114,700.00	4,093,005.00	21,695.00	99.5
2105	Нормативт зардал	22,590,500.00	20,629,530.00	1,960,970.00	91.3
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,012,200.00	4,012,200.00	00.00	100.0
210502	Хоол, хүнс	17,788,300.00	15,827,330.00	1,960,970.00	89.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	790,000.00	790,000.00	00.00	100.0

Баянхонгор сумын 5 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Багтагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	35,390,200.00	35,390,200.00	00.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	22,020,000.00	22,020,000.00	00.00	100.0
210602	Тавилга	9,600,000.00	9,600,000.00	00.00	100.0
210604	Урсгал засвар	3,770,200.00	3,770,200.00	00.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	164,500.00	110,000.00	54,500.00	66.9
210702	Дотоод албан томилолт	164,500.00	110,000.00	54,500.00	66.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,349,400.00	1,349,400.00	00.00	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	759,400.00	759,400.00	00.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	350,000.00	00.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	240,000.00	240,000.00	00.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10929600.00	10929600.00	00.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,320,000.00	8,320,000.00	00.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,609,600.00	2,609,600.00	00.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	676200.00	676200.00	00.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	676,200.00	676,200.00	00.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	676,200.00	676,200.00	00.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	562,316,300.00	555,344,587.00	6,971,713.00	98.8
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	467,229,500.00	465,214,030.00	2,015,470.00	99.6
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	467,229,500.00	465,214,030.00	2,015,470.00	99.6
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	95,086,800.00	90,130,557.00	4,956,243.00	94.8
132001	Орон нутгийн төсвөөс	95,086,800.00	90,130,557.00	4,956,243.00	94.8
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	32.00	32.00	00.00	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	25.00	25.00	00.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	06.00	06.00	00.00	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	32.00	32.00	00.00	100.0
650004	ССБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	17.00	17.00	00.00	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	15.00	15.00	00.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/ төгрөгөөр /	
		Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,923,800.00	12,293,540.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,923,800.00	12,293,540.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,923,800.00	12,293,540.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,923,800.00	12,293,540.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,923,800.00	12,293,540.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,923,800.00	12,293,540.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,923,800.00	12,293,540.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,923,800.00	12,293,540.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор сумын 5 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор сумын 5 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 1/18 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Тайлант хугацаанд тус байгууллагын төсвийн зарцуулалтад 1 дүгээр гарын үсгийг 2021.01.01-ээс 2021.05.17-ийг хүртэл Б.Ишмаа, 2021.05.17-оос 2021.12.31-ийг дуустал Ц.Мөнхтуяа, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч А.Саранцэцэг нар зурж төсвийг захиран зарцуулсан байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянхонгор сумын 5 дугаар цэцэрлэгийн зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Бага насны хүүхдийг асран хамгаалах, биеийн болон оюуны хөгжлийг дэмжих, хүнлэг бүтээлч иргэн болж төлөвшүүлэх, боловсролын суурь чадварыг эзэмшүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Баянхонгор сумын 5 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор сумын 5 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 628,231.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 9,423.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 6,596.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзээд, 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 9,075.9 мянган төгрөг байгаа тул, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянхонгор сумын 5 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,534.8 мянган төгрөгөөр буюу 0.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	46,895.0	84,887.8	37,992.8
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	46,895.0	84,887.8	37,992.8
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,272,209.2	1,227,681.7	(44,527.5)
Үндсэн хөрөнгө	1,474,053.1	1,477,315.2	3,262.1
Хуримтлагдсан элэгдэл	(201,843.9)	(249,633.6)	(47,789.7)
Нийт хөрөнгө	1,319,104.2	1,312,569.5	(6,534.8)
Өр төлбөр	20.5	85.2	64.6
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,319,083.7	1,312,484.3	(6,599.4)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,319,104.2	1,312,569.5	(6,534.8)

Бараа материалын дансны үлдэгдэл 84,887.8 мянган төгрөг болж 37,992.8 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материал, эм боох материал, бусад хангамжийн материал дансанд 26,602.9 мянга нийт 32,482.0 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,447,616.0 мянган төгрөг болж 3,262.1 мянган төгрөгөөр өссөн нь 29,142.1 мянган төгрөгийн хөрөнгө төсвийн хөрөнгөөр худалдан авч, аймгийн Засаг даргын Тамгын газраас 2,275.0 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлэн орлого авч бүртгэн, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 116 дугаар тогтоолоор 9,948.0 мянган төгрөгийн хөрөнгө акталж, 18,207.0 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгийн шинж чанар бүхий хөрөнгийг бараа материалын дансанд шилжүүлж бүртгэсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,312,569.5 мянган төгрөг болж 6,534.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 6,534.8 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд төсвийн нийт зарлагыг 803,529.5 мянга, санхүүжүүлэх эх үүсвэрийг 803,529.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 170,435.3 мянган төгрөгөөр бууруулж 633,094.2 мянган төгрөгөөр анх батлагдсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг 562,316.3 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр улсын төсвөөс 467,229.5 мянга, орон нутгийн төсвөөс 90,130.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 555,344.6 мянган төгрөгийг зарцуулж 2,015.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 555,344.6 мянган төгрөг буюу 98.8 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 4,956.2 мянга, нормативд зардлыг 1.961.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд Ковид-19 цар тахалтай холбоотой сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа БШУЯ, улсын болон аймгийн онцгой комиссоос өгсөн шийдвэр, чиглэлийн дагуу тусгай горимоор хичээллэсэн.

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 48 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 86.2 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 605,061.4 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 23,170.2 мянган төгрөгөөр буюу 3.7 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж бараа материалын зардал, дотоод албан томилолтын зардал, эд хогшил худалдан авах зардал өмнөх оноос нэмэгдсэн байгаа бол, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал нь өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд нийт 858,488.9 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 01, 04, 08 дугаар саруудад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлага, худалдан авалттай холбоотой 11,252.1 мянган төгрөгийн 7 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Байгууллагын төсвийн хөрөнгийн зарцуулалтад тогтоолын хэрэгжилтийг шалгахад дараах байдалтай байна.Үүнд:

- 2021 оны төсвийг 633,094.2 мянган төгрөгөөр анх баталсан ба тодотголоор 70,777.9 мянган төгрөг хасаж 467,229.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 95,086.8 мянган төгрөгийн мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр баталсан ба гүйцэтгэлээр 555,344.6 мянган төгрөг зарцуулсан байгаа нь анх батлагдсан төсөвт 12.3 хувийн хэмнэлт гаргасан байна.

- Байгууллагын байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг анх 103,040.5 мянган төгрөгөөр, тодотголоор 94,586.8 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 89,630.6

мянган төгрөг зарцуулж анх баталсан дүнгээс 13,409.9 мянган төгрөг буюу 13.0 хувь хэмнэсэн нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.8 дахь заалттай нийцээгүй байна.

- Бичиг хэргийн зардлыг 258.6 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 251.9 мянган төгрөг зарцуулж 2.6 хувийн хэмнэлт гаргасан байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайланд "Зөрчилгүй" санал дүгнэлт өгч, аудитаар нийт 12,693.3 мянган төгрөгийн 9 алдаа зөрчил илэрснээс 195.8 мянган төгрөгийн 1 алдааг санхүүгийн тайланд залруулж, 270.1 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 3,014.5 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага өгч, 6,782.2 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 4 зөвлөмж хүргүүлсэн байна.

Үүнээс төрийн албан хаагчийн буруутай үйлдлийн улмаас төрд учруулсан хохирлыг хуулийн дагуу шийдвэрлүүлэх 3,014.5 мянган төгрөгийн албан шаардлага биелээгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төрийн албан хаагчийн буруутай үйлдлийн улмаас төрд учруулсан хохирлыг хуулийн дагуу шийдвэрлүүлэх 3,014.5 мянган төгрөгийн албан шаардлагыг аймгийн Санхүүгийн хяналт аудитын албанд өгсөн ч биелээгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 594.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 594.1 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага өгч, Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллах 2 зөвлөмж хүргүүлэв.

4.1 Албан шаардлага

1. Ажиллагсдын цалинг 2021 оны 06, 07, 08 дугаар саруудад 594.1 мянган төгрөгөөр Нийгмийн даатгалын хэлтэст илүү мэдээлсэн байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх "ажил олгогч нь хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэсэн заалтыг зөрчсөн санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын хэлтэст зөрүүтэй мэдээлсэн ажилчдын 2021 оны 594.1 мянган төгрөгийн цалинг залруулж мэдээлж зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

4.3 Зөвлөмж

1. Тус байгууллага нь Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 144 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хугацаанд нь байршуулж, 01, 04, 08 дугаар саруудад 5 сая сая төгрөгөөс үнийн дүн бүхий худалдан авалт, тендерийн ерөнхий мэдээлэлтэй холбоотой 11252.1 мянган төгрөгийн 7 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5 дахь "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын

мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь мэдээлж цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

2. Байгууллагын ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг анх 103,040.5 мянган төгрөгөөр, тодотголоор 94,586.8 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 89,630.6 мянган төгрөг зарцуулж анх баталсан дүнгээс 13,409.9 мянган төгрөг буюу 13.0 хувь хэмнэсэн нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.8 дахь заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.8 дахь заалтыг хэрэгжүүлж, цаашид байгууллагын удирдлага дээд байгууллагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитаар өгсөн зөвлөмжийн бүрэн хэрэгжүүлж биелэлтийг нотлох баримтын хамт 2022 оны 05 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баянхонгор сумын 5 дугаар цэцэрлэг	2	594.1	-	-	-	-	1	594.1	2	-

_____оОо_____